# ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2024 оны 11 сарын 29 өдөр　　　Дугаар 240　　　Улаанбаатар хот

Сүлжээний дугаарлалтыг хэсэгчлэн буцаан авах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9, Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 74 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.4, 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Ондо" ХХК-ийн 2024 оны 24/44 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Харилцаа холбооны зохицуулах хороо болон "Ондо" ХХК-ийн хооронд байгуулсан 2022 оны 31500014 тоот "Ондо" ХХК-д олгосон сүлжээний дугаарлалтын гэрээ"-ний хавсралтаар олгогдсон сүлжээний дугаарын багцаас "60-(51-59)-xxxx, 60-(71-79)-xxxx, 60-8x-xxxx, 60-9x-xxxx, 66-2x-xxxx, 66-3x-xxxx, 66-4x-xxxx, 66-5x-xxxx", "66-7x-xxxx, 66-8x-xxxx, нийт 980,000 дугаарыг буцаан авсугай.
2. Сүлжээний дугаарлалтыг буцаан авсантай холбогдуулан тогтоол гарснаас өмнөх дугаарын төлбөрийн тооцоо нийлсэн акт үйлдэхийг Захиргааны удирдлага, хамтын ажиллагааны газар /З.Эрдэнэчулуун/-т даалгасугай.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан 2022 оны 31500014 тоот "Ондо ХХК-д олгосон сүлжээний дугаарлалтын гэрээ"-ний хавсралтад холбогдох өөрчлөлтийг тусган, гэрээг байгуулахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-т даалгасугай.

ДАРГА　　Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД　　Б.АНХБААТАР

Б.БАТЗОРИГ

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР